

Бизнес эрхлэгчдийн сэтгэгдэл



**“Енко Трейд” ХХК-ийн
захирал Г.Дариймаа**


Манай компани 2002 оноос хойш 16 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид Япон улсын эрүүл мэндийн бараа бүтээгдэхүүнийг оруулж ирж анх борлуулж эхэлсэн. Тухайн үед импортын бараа ховор мөн өрсөлдөгч байгаагүй, эрэлт хэрэгцээ ихтэй байлаа. 2002 оноос 2010 он хүртэл маш хурдтайгаар амжилтад хүрсэн. Бизнес маань амжилттай байх хугацаандаа би хуримтлал үүсгэж байлаа. Бизнесийн удирдлагын болон санхүүгийн мэдлэг дутуугаас болоод хуримтлалаа буруу зүйлд зарцуулж, 4 өрөө байраа 6 өрөө болгон, машинаа илүү том болгож, компанидаа хөрөнгө оруулалт хийх ёстой байтал өөртөө хөрөнгө оруулалт хийсэн нь үнэхээр бодлогогүй алхам байсан. Үүний улмаас банкны өрөнд ч орж, маш олон хэрэглэгчээ алдаж эхэлсэн. Ингээд би BPN-ийн сургалтыг сонсоод анх сууж үзсэн. Сургалтаас их зүйлийг сурч, тансаг хэрэглээнээс татгалзсанаар би санхүүгээ зөв удирдан, хуримтал үүсгэн, компанидаа хөрөнгө оруулалт хийсэн. Харин одоо миний сэтгэл санаа тайван амгалан болж бүх ажлууд зөв гольдролдоо орсон. BPN-ийн сургалтад хамрагдсанаар амьдралд минь олон сайхан өөрчлөлт гарсан. Та бүхэндээ маш их баярлалаа.



**“JSSS” ХХК-ийн захирал
Д.Мөнхтүвшин**

Миний хувьд маш их урам зориг авлаа. Одоо байгаа нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийж, өөртөө байгаа боломжоо олж харах мөн заавал цаг гарган төлөвлөгөөн дээрээ ажиллана гэсэн шийдвэр гаргалаа. BPN-ийн сургалт үнэхээр сайн байлаа. Өгөгдөж буй мэдээлэл цэгцтэй, их хэрэгтэй байж чадаж байна. Цаашлаад тусгайлан бизнесийн зөвлөгөө авах хэрэгцээ байна.



**“Хатхүлэг” ХХК-ийн
захирал Э.Хэрлэнтуул**


BPN-ийн хөтөлбөрт хамрагдсанаар маш олон боломжийг олж харсанаас гадна олон бизнес эрхлэгчидтэй танилцан, бид бүгд дээшээ тэмүүлсэн өөдрөг хүсэл мөрөөдөлтэй, амжилттай явж байна. Үүнд BPN-ийн сургалт, хамт олон маш их үүрэг гүйцэтгэж байгаа шүү гэдгийг мэдээсэй гэж бодож байна. Надад дадал зуршил болгож сургалтуудаас авч үлдэх зүйл их байлаа. Бүгдэд нь амжилт, эрүүл энхийг хүсье. Баярлалаа.



Хаяг:
СБД, 8-р хороо
Оюутны 33
"ТАНАН" төв, 404 тоот

Утас:
77113309, 70113309

И-Мэйл:
info@bpn.mn



Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



Оны дугаарт:

- Монгол салбарын үйл ажиллагаа хариуцсан захирлын үг
- Бизнес академи
- Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг
- Хөтөлбөрийн оролцогч Н.Нансалмаа
- Хөтөлбөрийн оролцогч Р.Баттөмөр
- М.Болормаа: “Бизнес эрхлэгчийн хувьд хамгийн чухал зүйлийг нэг доороос, богино хугацаанд мэдэж чадсан.”
- Бизнес эрхлэгчдийн сэтгэгдэл

2018





Маркус Эппер
ВРN Монгол салбарын
үйл ажиллагаа
хариуцсан захирал

Эрхэм хүндэт бизнес эрхлэгчид, хөтөлбөрийн оролцогчдоо

ВРN байгууллагын хувьд 2018 он олон онцлох үйл явдалтай, амжилт бүтээлээр дүүрэн он байлаа. Бид 2012 оноос хойш нийт 130 бизнес эрхлэгчийг дэмжин, хамтарч ажиллаж байна. 2018 онд бид шинээр 20 бизнес эрхлэгчийг хөтөлбөртөө хамрууллаа. Эдгээр компаниуд маань ажлын байр нэмэгдүүлэн, Монгол улсынхаа эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа билээ.

Бизнес академи өнгөрсөн онд нийт 18 бизнесийн удирдлагын сургалт, семинар зохион байгуулан, 250 гаруй бизнес эрхлэгчийг сургалтуудаа хамруулсан байна. Бид сургалтдаа бизнес сэтгэлгээ, хандлага, бизнесийн ёс зүйн үнэ цэнийг түлхүү оруулж өгдөг нь ВРN-ийн сургалтын гол онцлог юм. Сургалтад оролцсон нийт оролцогчдын 93 хувь нь манай сургалтыг сайн, маш сайн хэмээн үнэлдэг нь бидний ажлын амжилт билээ. Сургалтаас гадна бизнес зөвлөгөө авах хүсэлтэй бизнес эрхлэгчдийн тоо улам бүр нэмэгдэж байна. Бизнес зөвлөгөө нь бизнес эрхлэгчдэд бизнесээ амжилттай удирдан, төлөвлөхөд ихээхэн тус нэмэр болдог юм.

Дараагийн онцлох үйл явдал бол ВРN нийгэмлэгийн зүгээс Швейцарийн туршлага судлах бизнес аяллыг амжилттай зохион байгууллаа. Бизнес эрхлэгчид дэлхийд танигдсан “Viktorinox AG”, “Ronda AG” зэрэг үйлдвэрүүдээр зочлон, туршлага судаллаа. Аялалд оролцогчид "Бидний төсөөлж байснаас хамаагүй илүү байлаа" хэмээн аяллыг дүгнэн хэлсэн юм.

Түүнчлэн ВРN-ийн хөтөлбөрийн 2 оролцогч “Монголын Ажил Олгогч Эдийн Нэгдсэн Холбоо”-той хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан “Менежер бэлтгэх сургалт-хөтөлбөр”-т 1 сарын турш ХБНГУ-д мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдлаа.

2019 онд бид сургалтуудаа шинэчлэн, нэмэгдүүлэх ба манай сургалтыг Швейцарь болон Монгол туршлагатай сургагч багш нар удирдан явуулдаг билээ. Бид энэ оны 3-р сараас эхлэн “Зөрчлийн удирдлага” сэдэвт сургалтыг шинээр зохион байгуулна. Энэхүү сургалтад зөрчлийн янз бүрийн үе шатуудыг таньж мэдэх болон түүнийг хэрхэн даван туулах, өөрт ашигтай нөхцөл байдлыг бий болгох зэрэг

сэдвүүдийг оруулсан болно. Мөн бизнес эрхлэгчдийн хүсэлтээр тэдний бизнесийн онцлогт тохирсон тусгайлсан сургалтыг бид санал болгох болно.

Мөн энэ жил шинээр Швейцарь болон ХБНГУ-ын ахмад мэргэжилтнүүд бизнес эрхлэгчиддээ мэргэжлийн бизнесийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх ба манай хөтөлбөрийн оролцогч бүр бизнес зөвлөгөө авах боломжтой юм.

ВРN нийгэмлэгийн зүгээс 2019 онд олон үйл ажиллагааг хийхээр төлөвлөж байгаагийн нэг нь бизнес эрхлэгчидтэйгээ хамтарсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” юм.

Түүнчлэн ВРN нийгэмлэг 2019 оны 5-р сард дараагийн бизнес аяллаа зохион байгуулна. Бид аялалд оролцогчдынхоо үйл ажиллагааны чиглэлд тохируулан туршлага судлан, зочлох үйлдвэрүүдэд нарийн сонгон шалгаруулна. Та Швейцарийн бизнес эрхлэгчдийн амжилтад хүрсэн аргуудтай танилцан, туршлага судлахыг хүсч байвал бидэнд хандаарай.

Манай хөтөлбөрийн оролцогч хэлэхдээ "Би ВРN-ийг сонгосноор амьдралд ойр олон талын мэдлэг болон бизнес зөвлөгөөг авлаа. Цаашлаад нийгэмлэгээс зохион байгуулдаг үйл ажиллагаануудад оролцох сонирхолтой. Өөрсдийгөө хэрхэн амжилттай хөгжүүлэхийг мэдэхгүй олон бизнес эрхлэгчид байдаг. Тэдэнд би ВРN-ийг зөвлөж байна" гэж хэлсэн нь бидний цаашдын ажилд үнэхээр урам өглөө.

Та бидний тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг манай Facebook хуудас болон www.bpn.mn хаягаар авах эсвэл бидэнтэй утсаар холбогдон авах боломжтой.

2019 ондоо та бүхэнд хамгийн сайн сайхан, эрүүл мэнд, сэтгэл ханамж, ажлын амжилтыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.



Ц.Дуламрагчаа
Сургалт хариуцсан
зохицуулагч

2018 он “ВРN-Бизнес Академи”-ийн хувьд амжилт бүтээлээр дүүрэн жил болж өнгөрлөө. Энэ онд бид бизнес эрхлэгчиддээ зориулан “Санхүүгийн Менежмент, “Маркетинг” , “Хамт олноо удирдах” болон “Бизнесийн удирдлага” гэсэн 4 үндсэн сургалтыг Ханс Вилхэлм багшийн удирдлаган дор амжилттай зохион байгууллаа. Мөн үндсэн сургалтуудаас гадна “Хүний нөөцийн менежмент” , “Төслийн менежмент” , “Цагийн менежмент” сургалтыг 2 удаа бусад сургалтуудыг тус тус 1 удаа зохион байгуулсан юм. Дээрх сургалтуудад нийт 200 орчим бизнес эрхлэгч, хөтөлбөрийн оролцогчид хамрагдлаа. Сургалтууд маань оролцогчдын шаардлага, хүлээлтэд нь нийцсэн чанартай, өгөөжтэй байж чадсан юм. Түүнчлэн бид бүхэн улиран одож буй 2018 ондоо 11 удаагийн бизнес төлөвлөгөө болон санхүү бүртгэлийн сургалтыг 90 орчим бизнес эрхлэгчидийг хамруулан амжилттай сайн зохион байгууллаа.


Бид 2019 онд мөн үндсэн 4 сургалт , нэмэлт 4 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дашрамд дурьдахад ирэх 2019 онд “ВРN-Бизнес Академи”-ийн зүгээс хэд хэдэн үйл ажиллагааг шинээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Үүнд “Зөрчлийн менежмент” , Үйлдвэрлэлийн процессийн менежмент” гэсэн 2 сургалтыг бизнес эрхлэгчиддээ шинээр санал болгох болно. Мөн бизнесийн удирдлагын зөвлөгөөнөөс гадна хөтөлбөрийнхөө оролцогчдод зориулан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ахмад Мэргэжилтний Холбоо /Senior Experten Service/ мөн Швейцарь Улсын Swisscontact байгууллагын ахмад мэргэжилтэнүүдтэй хамтран үйлдвэрлэлийн шат дамжлага болгон дээр технологийн зөвлөгөөг өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн



Боловсрол эзэмшихийн зорилго нь
мэдэхэд бус хэрэгжүүлэхэд оршино.
Хэрбэрт Спэнсэр


шинээр бизнес эрхлэх гэж төлөвлөж байгаа Start up-Бизнес эрхлэгчдэд зориулан бизнесийн зөвлөх үйлчилгээг зохион байгуулна. Цаашид хөтөлбөрийн оролцогч ,бизнес эрхлэгчдээ шаардлагатай, эрэлт хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн сургалт, үйл ажиллагааг “ВРN-Бизнес Академи”-ийн зүгээс зохион байгуулах болно. Нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, баялаг бүтээж эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй үйлдвэрлэл эрхлэгч, үйлчилгээ үзүүлж буй хэн бүхэнд манай үүд хаалга нээлттэй. Та бүхэнтэй хамтран ажиллахдаа баяртай байна.



“Санхүүгийн менежмент”
2019.03.20 - 03.23 /4 өдөр/
Удирдагч: Ханс Вилхэлм

Зорилго: Сургалтаар санхүүгийн үндсэн ойлголтуудыг таниулах ба бизнес эрхлэгч компанийнхаа мөнгөн урсгалыг хянаж, зөв тооцоолсноор бизнесээ амжилттай удирдаж, зорилгодоо хүрэх мэдлэг чадвар эзэмшинэ. Мөн санхүүгийн тооцооллын аргууд, хугарлын цэг цаашилбал үйлдвэрлэлийн зардал болон ашгаа тооцох хэрэгслүүдтэй танилцаж, ашиглах сурах чадвар эзэмшинэ.

Ерөнхий агуулга: Эргэлтийн хөрөнгийн менежмент, санхүүгийн тайлан баланс, үр дүнгийн тайлан, тооцооллын чухал аргачлалууд, үнэ болон өртөг тооцох, хугарлын цэг



“Маркетинг”
2019.03.25 - 03.29 /4 ½ өдөр/
Удирдагч: Ханс Вилхэлм

Зорилго: Маркетингийн гол хэрэгслүүдийг бизнес эрхлэгчдэд таниулан, тэдгээрийг үйл ажиллагаандаа зөв хэрэглэх арга барилд суралцуулж, өөрийн бизнест тохирсон маркетингийн төлөвлөгөөг бие даан боловсруулах чадвар эзэмшүүлнэ.

Агуулга: Маркетингийн иж бүрдэл, хэрэглэгчидтэй харьцах, санал гомдлыг хүлээн авах, бизнес эрхлэгчийн зарчим: зах зээл, борлуулалтын сувгийг сонгох, маркетингийн гол хэрэгслүүд, маркетингийн төлөвлөгөө, төсөв, Mc Kinsey матриц эх мэт.



О.Эрдэнэсүрэн BPN нийгэмлэгийн үйл ажиллагаа

Улиран одож буй 2018 он бидний хувьд амжилт бүтээлээр дүүрэн арвин их туршлага хуримтлуулсан сайхан жил болж өнгөрлөө.

BPN Нийгэмлэг нь 2018 оны 7 дугаар сараас албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш “Бизнес аялал–Швейцарь.2018” туршлага судлах аяллыг амжилттай зохион байгууллаа. Швейцарийн бизнес эрхлэгчид ямар арга замаар амжилтад хүрч, зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүн нь яагаад чанарын өндөр төвшинд үйлдвэрлэгдэн, дэлхийд чанараараа тэргүүлдэг мөн бизнесээ хэрхэн амжилттай удирддаг вэ гэдгийг таньж мэдэн, туршлага судлах нь манай аяллын нэг гол зорилго байлаа.

Мөн BPN Нийгэмлэгийн зүгээс хөтөлбөрийн оролцогчиддоо “Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо”, ХБНГУ-ын талаас “GIZ” байгууллагууд хариуцан хэрэгжүүлдэг “Менежер бэлтгэх сургалт-хөтөлбөр” 30 хоногийн тэтгэлэгт хөтөлбөрийг санал болгосон билээ. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь Монгол улс дахь аж ахуйн нэгж, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг хурдасгах, Герман улсын шилдэг менежментийн тогтолцооноос суралцах, орчин үеийн шинэ техник технологи болон арга барилыг өөрийн бизнест нэвтрүүлэхэд туслах бөгөөд энэхүү хөтөлбөрт BPN нийгэмлэгээс “Тэргэл орд” ХХК-ийн захирал Х. Шинэцэцэг, “НЦЦМ” ХХК-ийн захирал, “АДАМ” эмнэлгийн үүсгэн байгуулагч, хүний их эмч Н. Нансалмаа нар амжилттай хамрагдлаа.

Бид Швейцарийн бизнес аяллыг жил бүр уламжлал болгон зохион байгуулах бөгөөд энэ жилийн аялал 5-р сарын 19-23-ны өдрүүдэд явагдана. Манай хөтөлбөрийн оролцогчдын нэлээдгүй хувийг нэхмэл болон сүлжмэлийн үйлдвэрүүд эзэлдэг. Иймээс бид энэ удаагийн аяллаар Швейцарийн томоохон сүлжмэлийн үйлдвэр болох “Beige Swiss Styling”-тай танилцан, туршлага судлахаар боллоо.

Түүнчлэн сүүлийн үед хөтөлбөрийн оролцогчдын анхаарлыг



ихээр татаж байгаа хог хаягдлыг дахин боловсруулан ашиглах талаар илүүтэй туршлага судлахаар төлөвлөж байна. Ингэснээр бид байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад түлхэц үзүүлэн ажиллахыг зорьж байгаа билээ.

“АДАМ” эрэгтэйчүүдийн эмнэлгийн захирал, АУ-ны доктор, ахлах зэргийн эмч Н.Нансалмаа

Миний бие BPN-ээс санал болгосон ХБНГУ-ын GIZ буюу Германы Эдийн засгийн Яамны хамтын ажиллагааны хөтөлбөр болон Монголын Ажил олгогч Эздийн Нэгдсэн Холбооны хамтарсан “Эрүүл мэндийн салбарын менежер”-ийн сургалтын сонгон шалгаруулалтад орох боломж гарав. Сонгон шалгаруулалт нь англи хэл дээр байсан ба Герман улсаас та юу сурах, хэрхэн хамтын ажиллагаа хийх төлөвлөгөөтэй болохыг үндэслэсэн байлаа. Ингээд сонгон шалгаруулалтад тэнцсэн таван эмэгтэй Герман улсын Baden Württemberg мужийн Tübingen хотод энэхүү сургалтад 30 хоног, 7 орны 20 гаруй хүмүүстэй нэг анги болж суралцах маш сайхан боломж олдсон юм.

Энэхүү хөтөлбөр нь дараах хэлбэрүүдээр явагдлаа.

–“Tübingen”-ийн их сургуулийн дэргэдэх Export Academy of Baden Württemberg сургалтын тэнхимд 6 өдрийн эрчимжүүлсэн ерөнхий менежментийн хичээл, мэргэжлийн багш нарын менежерийн сургалт, семинар.

–Германы эрүүл мэнд, түүнтэй холбоотой “Aescular” AG, “Alber” GmbH, “CeGat” GmbH, “Karl Storz” GmbH&Co, “Asanus” GmbH, “Erbe” Elektro Medizin GmbH зэрэг нийт 16 компани, жижиг дунд бизнесүүдээр зочилж үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах.

–Өөрийн сонирхсон, урьдчилан тохирсон компани дээр биеэр очиж хамтын ажиллагааны эхлэл тавих, бизнесээ өргөжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлтэй байв.



Хөтөлбөрийн оролцогч

АУ-ны доктор, ахлах зэргийн эмч Н.Нансалмаа

Тэнхимийн сургалтуудад та хэрхэн 2 минутад өөрийн үйл ажиллагааг хүнд сонирхолтойгоор танилцуулж, хөрөнгө оруулалтын талаар ярилцах үндэс тавих, төсөл бичихэд юу анхаарах, хэрэв гадны түнштэй хамтрах гэж байгаа бол бизнес эхлэхэд тухайн орны ямар хуулийг эхлэн судлах шаардлагатай вэ гэх мэт амьдралд нэн ойр хөтөлбөрүүд орсон байв.

Түүнчлэн бид дэлхийд тэргүүлж буй маш том, мөн дийлэнх нь гэр бүлийн, жижиг хэмжээний 40-50 орчим ажилтантай олон компаниудаар зочиллоо. Заримаас нь товч дурдахад:

- Freiburg хотын “Uni Clinic” их сургуулийн эмнэлэг нь европын орнуудаас өвчтөнд зуучилж оношилгоо, эмчилгээ, хяналт хийх эмнэлгийн туризмыг шинээр хөгжүүлж байна.
- “CeGat” генетикийн лабораторид 20 хүн л ажилладаг боловч генийн дараалал тогтоох шинжилгээг дэлхийн 100 гаруй орноос авч хийдэг.
- Оношилгоо болон мэс заслын дурангийн дэлхийд тэргүүлэх үйлдвэрлэгч “Karl Storz” компани дэлхий даяар 12,000 ажилтан бүхий хүчирхэг компани болтлоо хөгжсөн түүхэн замнал болон, хагалгааны өрөөг хэрхэн ухаалаг шийдэлтэй болгож, 3D технологиор цээжний болон хэвлийн хөндийн, бөөр шээсний замд дурангийн хагалгааг хийж байгаа технологийн хөгжлийг гайхан биширч байлаа.
- Aescular мэдрэлийн болон мэс заслын багаж үйлдвэрлэгч нь нугас нурууны болон хиймэл үенүүдийг робот ашиглан үйлдвэрлэж байна.
- ASANUS компани нь их сургуулийн эмнэлгүүд болон томоохон эмнэлгийн мэс заслын багажийг нэг бүрчлэн ялган бүртгэх ажлыг компьютерчилж цаг, хөдөлмөр хэрхэн хэмнэх үйлчилгээг сүүлийн 3 жилд нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ технологийг дэлхийн 10 гаруй оронд нэвтрүүлсэн ба инновацид суурилсан



“...үргүйдлийн болон түрүү булчирхайн үрэвслийн эмчилгээний Герман Улсад дагаж мөрдөж буй стандартуудыг судалж, өөрийн эмчилгээндээ нэвтрүүлээ.”

үйлчилгээ нь тус компанид эдийн засгийн бишрэм амжилтыг авчирчээ.

Герман улсад жил бүр болдог дэлхийн хамгийн олон оролцогч бүхий эрүүл мэндийн салбарын “Medica Expo show” нь шинжлэх ухаан, технологийн дэвшил хэрхэн анагаах ухаанд хэрэгжиж байгааг харах, бизнес эрхлэгчдийн хамтрагчаа олох нөхцөл бололцоог бүрдүүлсэн арга хэмжээ байлаа.

Ганцаарчилсан уулзалтын хувьд манай эмнэлэг Giessen хотын “Justus-Liebig”-ийн их сургуулийн Андролог, Урологийн төвд үргүйдлийн болон түрүү булчирхайн үрэвслийн эмчилгээний Герман Улсад дагаж мөрдөж буй стандартуудыг судалж өөрийн эмчилгээндээ нэвтрүүлээд байна.

Мөн Герман улсаас давсагны дурангийн оношилгооны аппарат худалдан авч давсаг түрүү булчирхайн дурангийн оношилгоог 2019 оноос манай эмнэлэг эмчилгээндээ шинээр хэрэглэж байгаа нь энэ аяллаас олж авсан маш том аяны “богц” маань боллоо .

Чанартай үйлчилгээтэй, орчин үеийн техникийн дэвшил хослуулсан, нэр хүнд бүхий эмнэлэг удаан орших эсэх нь эмчийн чадвараас гадна тухайн эмнэлгийн алсын хараа, төлөвлөгөө, түүнд хүрэх арга зам, хүний нөөц, сахилга бат, тэдгээрийг зөв удирдах менежмент гэх мэт олон хүчин зүйл, хамтын хөдөлмөрийн үр дүн гэдгийг BPN сургалтуудаас сурч, Герман улсад нэг сар суралцах үеэрээ биеэрээ үзэж урам зориг авсандаа талархаж байна.

Танай хамт олонд улам их амжилт хүсэн ерөөе.



Хөтөлбөрийн оролцогч Р.Баттөмөр

ВРN-Нийгэмлэгээс 2018 оны 10 сард зохион байгуулсан “Бизнес аялал–Швейцарь.2018” туршлага судлах аялалд хөтөлбөрийн оролцогчийн зүгээс миний бие хамрагдсан юм.

Аяллын онцлог нь үйлдвэрийн нэлээн гүнд нь орж, үйлдвэрлэлийн процессийн нарийвчилсан хэсгүүдтэй танилцан, тэдний бүтээгдэхүүнийг амсаж, нүдээрээ харж, хамраараа үнэрлэж явлаа. Бизнес эрхлэгч бүр үйлдвэрээсээ гарч буй хог хаягдлыг дахин боловсруулан үйлдвэрлэлдээ эргүүлэн ашиглаж байсан нь бидэнд нэгийг бодогдуулж хоёрыг эргэцүүлэхэд хүргэж байлаа.

Манай сургагч багш Ханс Вилхэлм “Швейцарь улс ямар ч байгалийн баялаггүй, газар нутгийн хувьд Монголын нэг аймгийн нутаг дэвсгэртэй тэнцэх газар нутагтай. Харин Монгол улс асар уудам том газар нутагтай, байгалийн баялаг ихтэй . Гэхдээ Монголд жирийн мужаан 350 еврогийн цалин авдаг, харин Швейцарьт жирийн мужаан 3000-4000 еврогийн цалин авдаг. Яагаад ийм их ялгаатай байна вэ?” гэж биднээс асуудаг. Энэ асуултын хариултыг энэ аяллаараа гүнд нь орж, мэдэхийг хичээж явлаа.

Зочилсон үйлдвэр болгон маань биднийг маш найрсаг, халуун дотноор хүлээн авч нуух зүйлгүйгээр үйлдвэрээ танилцуулж байсан. Бид өдөрт 2 үйлдвэртэй танилцаж байсан бөгөөд үйлдвэр болгон дээр түүхий эд материалаа татахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн болон гарах хүртэлх бүх үйл явцтай танилцахад хагас өдөр хүрэлцэхээргүй байсан ч бид богино хугацаанд их зүйл үзэж харахыг хичээж явлаа.

“Бизнес хийнэ гэдэг нь зөвхөн мөнгө олох эсвэл хэн нэгнийг дуурайж хийхдээ биш харин хүний хэрэгцээг хангах, хэрэглэгчид ямар асуудал байна түүнийг нь шийдвэрлэхэд оршдог”

Тэд үйлдвэрээ аав ээжээсээ өвлөгдөн ирсэн жижигхэн үйлдвэр хэмээн танилцуулж байсан. Гэвч танилцаад харахаар үнэхээр том, гадаад дотоод худалдаа нь сайн хөгжчихсөн маш амжилттай яваа компаниуд байсан юм.

Тэдний амжилтын нэг гол шалтгаан нь тэд хэн нэгнээс эсвэл ямар нэгэн зүйлээс хараат бус байж чаддаг оршиж байсан. Жишээ нь: бидний сайн мэдэх “Vistogroup” хутганы үйлдвэр хог хаягдлаа дахин боловсруулж үйлдвэрээ болон тосгоныхоо айл өрхийг дулаанаар хангадаг юм байна. Дараагийн бидний зочилсон нийтийн хоолны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл худалдаа эрхэлдэг “Hugentobler” АГ үйлдвэр мөн адил герман технологиор дулаанаа газрын гүнээс авдаг. Ихэнх үйлдвэрүүд иймэрхүү тогтолцоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг аж.

Энэ болгоноос харахад бизнес хийнэ гэдэг нь зөвхөн мөнгө олох эсвэл хэн нэгнийг дуурайж хийхдээ биш харин хүний хэрэгцээг хангах, хэрэглэгчид ямар асуудал байна түүнийг нь шийдвэрлэхэд оршиж байгаа юм байна гэдгийг ойлгож авлаа.

Хөтөлбөрийн оролцогчид бид энэхүү аяллаар маш их зүйлийг үзэж, судлан, өөрсдийн бизнесээ хэрхэн цаашид амжилттай удирдах талаар олон шинэ санаатай ирж чадлаа. Энэ дашрамд аяллыг амжилттай сайн зохион байгуулсан ВРN-ийн баг хамт олондоо баярласнаа илэрхийлье.

Хөтөлбөрийн оролцогч М.Болормаа

Та өөрийгөө болон компаниа бидэнд танилцуулна уу?

Намайг Болормаа гэдэг. Мөнхийн Болор компанийг 2003 онд манай аав ээж хоёр анх үүсгэн байгуулж 15 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулсаар ирлээ. Манай компани 30 гаруй нэр төрлийн хиам, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд нийлүүлж

байна. Миний хувьд Хятад болон Австрали улсад олон улсын хууль эрх зүй болон бизнесийн удирдлагаар мэргэжил эзэмшин, 2013 оноос хойш компанидаа ажиллаж байна. Энэ компани нь гэр бүлийн компани, манай аав ээж хоёр надад өвлүүлэн өгч байгаа.

Анх ВРN-ийн тухай хаанаас олж мэдсэн бэ?

Би анх ВРN-ийн мэдээллийг нэг бизнес эрхлэгч танилаасаа сонсоод шинэ зүйл сурч мэдье гэсэндээ дэлгэрэнгүй мэдээлэл аван ирж байсан. Анх санхүүгийн менежмент болон маркетингийн сургалтад суусан. Би өөрийгөө гадаадын болон дотоодын сургууль төгссөн, үзэж сурсан зүйлтэй гэж боддог байлаа. Гэтэл ВРN-ийн сургалтаар зааж байгаа зүйл нь амьдралд ойр, бодит жишээн дээр тулгуурласан, одоогийн нөхцөл байдалд уялдсан сургалтад би өмнө нь сууж байгаагүй.

Би сургалтад сууснаасаа хойш төлөвлөлт, төлөвлөгөө, хуримтлал үүсгэх, эрсдэлээ тооцоолох, санхүүгээ хэрхэн хөтлөх зэрэг бизнес эрхлэгчийн хувьд хамгийн чухал олон зүйлийг нэг доороос, богино хугацаанд мэдэж авч чадсан.

Манай жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд бизнесээ цаашид яаж хөгжүүлэх вэ гэдгээ мэдэхгүй мухардалд ороод гацчихсан хүмүүс зөндөө байдаг. Би бага ч гэсэн дэмжлэг болох үүднээс бизнесээ хэрхэн амжилттай удирдах талаар мэдлэгтэй болж, шинэ зүйл мэдэж аваасай гэсэндээ ВРN-ийн

мэдээллийг танил бизнес эрхлэгчиддээ цааш нь танилцуулж хэлдэг.

Таны алсын хараа юу вэ?

Миний алсын хараа монгол малынхаа махыг гадаад орнуудад таниулан экспортод гаргах, цаашлаад Монгол улсынхаа эдийн засагт хувь нэмрээ оруулах юм. Монгол малын мах нь химийн нэмэлт бэлдмэлээр бордоогүй, олон төрлийн эмийн ургамалаар баялаг бүтээгдэхүүн учир манай улсын үнэт зүйлдээ ордог. Анх манай үйлдвэр нээгдэж байхад зах зээл дээр тийм ч олон ижил төрлийн үйл ажиллагаатай компаниуд байгаагүй. Одоо харин мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл үнэхээр хурдацтай хөгжиж байна. Олон ч өрсөлдөгчид гарч ирсэн. Тэрнийхээ хэрээр бүтээгдэхүүний чанар нэмэгдэн, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээгдэхүүнүүд зах зээлд нийлүүлэгдэн, өрсөлдөөн нэмэгдэж байгаа.

Залуу бизнес эрхлэгчийн хувьд өөрийн хүсэл мөрөөдлөө бидэнтэй хуваалцаач.

Анх би энэ бизнест албан хүчээр шахуу орж байсан. Одоо миний хүсэл мөрөөдөл, хийхээр бодож төлөвлөж байгаа зүйл маш олон байна. Хүн мэдээж нэг байрандаа байгаад байхыг хүсэхгүй, өсөн дэвжиж, олон хийж бүтээсэн зүйлтэй байх хэрэгтэй. Би энэ үйлдвэрээс салбарлан, олон ажил хийхээр 4 жилийн төлөвлөгөөндөө тусгасан байгаа. Цаашлаад өөрийн хүсэл мөрөөдлөө улам л том болгох зорилготой байна.

Танд баярлалаа. Цаашид ажилд тань өндөр амжилт хүсье.

